

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

БОДОНЧАР МУНХАГ ХЭМЭЭХИЙН УЧИР

Б. ЛХАГВАДОРЖ . Хөдөө аж ахуйн их сургууль

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлд тэнгэрийн гэрлээр жирэмсэлсэн хэмээх Алунгоо эхийн отгон хүү, Чингис хааны дээд өвөг Бодончарыг юуны учир мунхаг хэмээснийг өөрт буй баримт сэлтэд тулгуурлан тайлбарлахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: Мунхаг, үтээрэх, боржигин, Бодончар, Алунгоо

МНТ-оос ...Алангоо бэлэвсэн бөгөөтөл гурван хөвгүүн төрүүлэв. Бугу хатаги, Бугуту салжи, Бодончар мунхаг нэртэй бөлгөө¹/§17/ гэжээ.

Энд дурьдагдаж буй мунхаг хэмээхийг эрдэмтэд, судлаачид өөр өөрийн үзэл бодол, баримт сэлтийн үндсэн дээр тайлбарласан байдаг. Тухайлбал “Хүүхэн цагаас усгал номхон ихэмсэг аливаа үйлсийг хэрэгсэлгүй үтээрэхүйд үл ажиглах үтээрэх хэмээнэ олонжин тэнэг болгон санаад Бодончир мунхаг хэмээн нэрийдэв². Мөн Бодончарын ааль дүр нь бусдаас үлэмж төв чигтэй, усгал номхон бөгөөд үг цөөтэй тул ах нар нь тэнэг хэмээн доромжилж³ гэжээ.

Судлаач Ч. Баянжаргалын үзсэнээр: . . . Бодончар мунхаг гэдэг нэрийг . . . бутач хөвгүүдээ хайрлан хамаг санаа сэтгэлээ зориулж . . . Алун-гоо эх отгон хөвгүүндээ өгсөн байна.⁴

Алан гоогоос бутач /бутач Б.Л/ хөвгүүн төрсний тул, Бодончар хэмээгээд, тэр хөвгүүн үтэл энгийн Б.Л/ хүний хөвгүүн адил зан ааль үгүй, аливаа юмыг хайхрахгүй, дөлгөөн донгио зантай, асууваас ялгам үл өгүүлдэг тул тэнэг мунхаг болгон санаж, Бодончар мунхаг хэмээн нэрийджээ.⁵ Гэсэн бол Дарма гүүш: Бодончарын дүр байдал нь энгийн хүнээ өөр, хүнд, номхон,үг цөөн ажгуу. Хоёр ах нь хурц, эрс догширгон бөгөөд Бодончарыг мунхаг хэмээн дарлахуйд Алаг хатан өгүүллүүн: “Энэ хөвгүүн мунхаг бус,хөйт үеийн дотор эрх үгүй эрхэм болмуй⁶ гэжээ.

Эрдэмтэн Г.Сүхбаатар “. . . Мунхаг гэдэг нь мугулюй гэдэгтэй холбогдох нь тодорхой байна⁷ гээд Мугулюй гэдэг угсаатны нэрийг тэмдэглэсэн үг Монгол хэлний мухар гэсэн үг байж болмоор байна⁸ гэжээ. Тэгээд “. . . эрх мэдэлгүй, эрх мэдлийн бэлгэдэлгүй гэдгийг эвэргүй буюу мухар гэдэг байна.⁹ Мөн . . . Мунхаг хэмээх дагавар нь “мухар” буюу эрх мэдэлгүй гэсэн утгатай нэмэлт хоч буюу доромж нэр байсан . . . боржигин овгийг тэргүүлэх болсон үеэс орхигджээ.¹⁰ гэсэн бол . . . Бодончар угтаа гэм хийж шийтгүүлсэн хүн байсан бололтой . . . хаад ноёдыг гэм хийснийх нь шийтгэл болгодог . . . Боржиголох ёс нь тийм том ял бус, ухааны мунхарлыг өөрөөр нь арилгуулах процесс байсан.¹¹ Мөн ...

¹ Цэрэсодном.Ц МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар. УБ. 2000. 17 дахь тал

² Гомбжав. Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив. УБ, 1992. 5 дахь тал

³ Рашунцаг Болор эрх УБ, 2006. 21 тал

⁴ Баянжаргал.Ч Чингис хааны гүн ухаан, шинэ мянган УБ, 2006. 75 дахь тал

⁵ Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст бичиг” 2006. 35 дахь тал

⁶ Мэргэн гэгээн Лувсандамбижалцан “Алтан товч” УБ, 2006. 54 тал

⁷ Сүхбаатар.Г “ Монгол-Нирун улс ба МНТ “ МНТ-ны 750 жилийн ойд зориулсан ОУ-ын бага хураг 28 тал УБ, 1995

⁸ Сүхбаатар.Г Монгол-Нирун улс. УБ.,1992. 177 дахь тал

⁹ Мөнгэнд 177 дахь тал

¹⁰ Энхиаг.А Бодончар мунхаг нэрийн тухайд МУИС-ын ЭШБ түүх 2 УБ , 2003 № 211 /20/

¹¹ Баяр.Ё Чингисийн үзэл ертөнцийн язгууртай болохын учир УБ, 1998. 36 дахь тал

дайсныхаа өөдөөс эргэх буцахаа умартан мунхагаар хадран довтлогч зэрлэг бодон гахай лугаа адил эрэлхэг зоригтон /дайчин баатар/ гэсэн эртний уламжлалт нэр мөн¹² гэжээ.

Гэтэл бядуу хэмээн хөөгдөхдөө тэрбээр энэхүү хочийг авсан байжээ. Дээрх саналууд нь баримт нотолгоо багатай байгаа улс төрийн бутрал, манжийн эрхшээлийн үед зохиогдсон монгол сурвалжуудын сэдэвтэй холбогдох мэдээ нь бие биенээсээ хуулсан, дам ишэлсэн шинжтэй байгаа нь асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.

Энэхүү өгүүлэлдээ МНТ-ны мэдээн дээр тулгуурлаж дээрх асуултанд хариулт өгч болно хэмээн үзлээ. /Б.Л/

Бодончар мунхаг хэмээх нэр МНТ-ны 17, 19, 23, 30 зүйлүүдэд гарч байгаа бөгөөд дангаараа Бодончар хэмээх нэр МНТ-н 24, 28,29,32,33,34,35,37,38,40.41.42.43.44 зүйлүүдэд мунхаг хэмээх тодотгол үл авчээ. МНТ-нд Бодончар мунхаг хэмээх нэр нийтдээ 18 удаа гарч байгаагийн 4-н удаа хамтдаа буюу Бодончар мунхагаараа, 14 нь дангаараа Бодончар гэж оржээ.

Дээрх нэр нь 17-р зүйлээс 44-р зүйл хүртэл 18 удаа дурьдагдаж байгаагийн гагцхүү 30-р зүйл дээр: 23-р зүйлээс хойш мунхаг гэдэг тодотголыг хэрэглэхгүй Бугу хатаги ах нь Бодончар мунхаг дүүгээ энэ Онон мөрөн рүү явлаа гэж эрж ирээд /§30/ гэжээ.

Энэхүү мэдээ нь Бугу хатаги Бодончар мунхагийг ухаажиж өөр хүн болсныг мэдээгүйг харуулдаг. Энэ нь МНТ-ны 33.34.35.37 /§-д/ дэх үйл явдлуудаар батлагдаж байна.

Жишээлбэл: Бодончар . . . хатирч явах зуур өгүүлрүүн “Ахаа ахаа бие түрүүтэй дээл захтай сайн хэмээв. Бугу хатаги ах нь тэр үгий нь юман тоонд эс бодов¹³. /§33/ гэжээ. Мөн үгээ өгүүлбээс ах нь мөн юман тоонд үл болгон хариуд нь үл дуугарав. Бодончар . . . бас мөнхүү өгүүлэв. Ах нь өгүүлрүүн /Бугу хатаги Б.Л/ “Түрүүнээс хойш дахин дахин ямар үг өгүүлнэ чи¹⁴ /§34/ гэв.

“. . . Бодончар өгүүлрүүн “Саяын түнхэлэг горхиноо бүхий иргэн их бага, муу сайн, адаг түрүү үгүй эн сацуу буй . . . Бид тэднийг дагуулья хэмээв¹⁵. /§35/ Ах дүү нартайгаа хэлэлцээд буцаж мордов. Бодончарыг хошууч болгон довтолгов¹⁶/§37/ гэжээ. Энэ бүхэн дээрх санааг батлах мэт.

Алангоо эх юүгээ үгүй болсны хойно . . . адуу мал идээ хөрөнгөө хуваалдахад . . . Бодончар мунхагийг бядуу гэж урагт үл тооцон хувь эс өгөв¹⁷ /§32/ гэжээ. Дээрх баримтанд а. ах дүү тавуул эд хөрөнгөө хуваасан б. Бодончарт мунхаг, бядуу гэж хувь эс хүртээжээ.

Дурьдагдсан бядуу хэмээхийг “болхи, дорой, ухаан мулгуу, бядуу дорой, бядуу ядуу¹⁸ гэжээ.

Өгүүлэн буй үед Бодончар отгон хүү эрх танхи мунхаг байжээ. МНТ-оос Өэлүн эхийн бага хөвүүн элгэмсэг Отчигин хэмээгдюү

Эрт унтагч

Орой босогч

Баргаас үл хоцорюу

Байдлаас үл хожидюү¹⁹/§195/ гэжээ. Отчигины адилаар Бодончар отгон хүү бөгөөд эрх танхи өссөн учраас амьдрал мэддэггүй байсныг мунхаг хэмээх тодотголоор өгүүлжээ.

¹² Эрдэнэбат.У “МНТ-ны Алун-гоо эхийн домгийн учир” УБ, 1997. 84 дэх тал

¹³ Цэрэнсодном.Ц МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар УБ. 2000. 35 дахь тал

¹⁴ Мөн тэнд 35 дахь тал

¹⁵ Мөн тэнд 35 дахь тал

¹⁶ Мөн тэнд 35 дахь тал

¹⁷ Цэрэнсодном.Ц МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар УБ. 2000. 33-34 дэх тал

¹⁸ Цэвэл.Я Монгол хэлний товч тайлбар толь УБ.,1960. 125 дахь тал

¹⁹ Цэрэнсодном.Ц МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар. УБ. 2000. 121 дахь тал

Монгол ардын билэг зүйн дурсгалаас үзвэл

Мэргэн хүн мэдэж туслах
Мунхаг хүн албадаж туслах
Мэргэн хүн хойчоо бодох
Мунхаг хүн идэхээ бодох
Мэргэний эрдэм дотроо
Мунхагийн эрдэм гаднаа²⁰ гэх мэтээр өгүүлжээ. Гэтэл

Муруй сумыг засвал бай онож болно

Мунхаг хүнийг сургавал цэцэн болж мэднэ²¹ гэжээ.

Энд дурьдахгүй өнгөрч болохгүй нэгэн санаа байгаа нь “Мунхаг” хэмээх нь тэнэг ухаан солиотой биш бөгөөд эрх танхи байсныг өгүүлсэн бололтой.

Хожим нь Бодончар мунхаг хэнээс ч илүү цэцэн билэгтэн болсон билээ. Гэхдээ Бодончарыг сургасан сургууль амьдралын хүнд хэцүү байсан ажгуу.

МНТ-оос Бодончар урагт эс тоологдож энд юу хийж сууна ... үхвэл үхье сэхвэл сэхье гэж Балжийн аралд хүрч өвсөн эмбүүл гэр барьж ан суув²² /§24/ борогчин харцага хар хурыг барьж идэхийг үзэж ... урхидан барьж тэжээв.²³ /§25/ мөн ... чонын гууд хоргоосон гөрөөсийг мярааж харваж алж иднэ. Бас чонын идсэн сэгийг түүж идээд ... тэр он гарав²⁴/§26/ гэх мэтээр түүний амьдрахын төлөөх тэмцлийг илэн далангүй тэмдэглэжээ. Тэгвэл Шагжийн тольд мунхаг хэмээхийг : Хүмүүний зэргийн тэнэг харанхуйг нь бас аливаа юмны тодорхойгүйг²⁵ гэжээ.

Өөрсдийгөө дээд тэнгэрээс гаралтай хэмээн үздэг Чингисийн угсааныхан дээрх баримтуудыг яагаад? Нууц түүхэнд оруулах болов гэдэг нь сонирхолтой миний санааг батлах мэт Бодончар урагт эс тоологдож Балжийн арал хүрэхээр явснаас эхлэн мунхаг хэмээх тодотголыг 24-р зүйлээс эхлэн /гагц 30/ хэрэглэхгүй байгаа нь түүнийг амьдралын сургуульд суралцсаныг гэрчилж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаан дээр үндэслэн:

1. Бодончар нь отгон хүү байсан ба эрх танхи өссөн тиймийн учир мунхаг, бядуу хэмээн тодотгожээ. Гэхдээ энэ нь ухаан солиотой, мангар тэнэг гэсэн үг биш
2. Дээрх санаа нь ардын аман зохиол болон бусад сурвалжууд мөн МНТ дээрх баримтуудаар батлагдаж байна.
3. МНТ-ний 24-р зүйлээс эхлэн мунхаг хэмээхийг хэрэглэхгүй байгаа нь /гагц 30-р зүйл/ түүнийг амьдралын сургуульд суралцаж нийгэм улс төрийн буюу овгийн амьдралд идэвхтэй оролцож эхэлснийг гэрчилж байна

Abstract: I tried to put toward a proposal in this academic paper, about Bodanchir who is sayed that senior ancestor of Chinggis khan, Alungoo's youngest son who conceived by solar of heaven and sky and revealing what the reason he is noted that “Foolish” in Secret History of Mongolia.

²⁰ Заяабаатар. Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж. УБ., 1997. 822 дахь тал

²¹ Мөн тэнд 821 дэх тал

²² Цэрэнсодном.Ц МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар УБ. 2000. 121 дэх тал

²³ Мөн тэнд 34 дэх тал

²⁴ Мөн тэнд 34 дэх тал

²⁵ Шагж. Монгол үгийн тайлбар 1994 он. 142 дахь тал

Ном зүй

- Ч. Баянжаргал. Чингис хааны гүн ухаан, шинэ мянган. УБ, 2006
Ё. Баяр. Чингисийн үзэл ертөнцийн язгууртай болохын учир. УБ, 1998
Гомбожав. Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив. УБ, 1992
Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст бичиг” УБ., 2006 он
Ц. Заяабаатар. Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж. УБ., 1997
Г. Сүхбаатар. Монгол-Нирун улс. УБ., 1992
Ц. Цэрэнсодном. МНТ-ны ЭШ-ний орчуулга тайлбар УБ. 2000
Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1960
Шагж. Монгол үгийн тайлбар. УБ., 1994 он
У. Эрдэнэбат. МНТ-ны Алун-гоо эхийн домгийн учир. УБ, 1997